



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1998 оны 1 дугаар
сарын 26 өдөр


Дугаар 6-12

Улаанбаатар
хот

Дүрэм батлах тухай

1. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцааны хэлтсийн дүрмийг хавсралт ёсоор баталсугай.
2. Хэлтсийн дүрмийг чанд баримтлан ажиллахыг Гадаад харилцааны хэлтэс (Б.Баясгалан)-д үүрэг болгосугай.



 Ж.НАРАНЦАЦРАЛТ

Нийслэлийн Засаг даргын 1998 оны 1 дүгээр сарын 26-ны 6-12 тоот захирамжийн хавсралт

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ГАДААД ХАРИЛЦААНЫ ХЭЛТСИЙН ДҮРЭМ

Нэг . Нийтлэг үндэслэл :

- 1.1. Гадаад харилцааны хэлтэс нь нийслэлийн төр, захиргааны байгууллагын гадаад бодлогыг тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон төлөвлөгөө боловсруулах, гадаад үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, зохион байгуулах, зохицуулах хийгээд хэрэгжилтэд нь хяналт тавих зорилго бүхий нэгж мөн.
- 1.2. Нийслэл хотын хөгжлийн бодлого, чиглэлийн дагуу төрөл бүрийн салбарт гадаад орны нийслэл болон бусад хот, олон улсын байгууллага, үйлдвэрлэл, бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчидтай харилцаагаа өргөтгөх, Улаанбаатар хотын хөгжил, нийгмийн асуудлыг шийдэхэд гадаад харилцаа, хамтын ажиллагааг оновчтой ашиглахад Гадаад харилцааны хэлтсийн ажлын гол чиглэл оршино.
- 1.3. Гадаад харилцааны хэлтэс нь Нийслэлийн Засаг дарга, түүний Тамгын газрын өдөр тутмын болон Монгол улсын Гадаад харилцааны яамны мэргэжлийн удирдлагын дор ажиллаж Засаг даргын Тамгын газарт ажлаа тайлагнана.
- 1.4. Гадаад харилцааны хэлтэс нь нийслэлийн дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын гадаад харилцааны үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, ажлын зөвлөлгөө өгч чиглэлийг нь тодорхойлон хяналт тавина.
- 1.5. Гадаад харилцааны хэлтэс нь нийслэлийн Засаг даргын дэргэдэх газар, хэлтсийн гадаад үйл ажиллагааны ерөнхий чиглэл, бодлогыг тодорхойлон зохицуулж хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажиллана.
- 1.6. Гадаад харилцааны хэлтэс нь жил, улирлын төлөвлөгөөтэй байх ба хэлтсийн зөвлөлгөөнийг сар тутам, шуурхай зөвлөлгөөнийг 14 хоногт хийнэ. Хэлтсийн зохион байгуулагч нар ажил үүргийн тодорхой хуваарьтай байж, ажлаа жил, улирлаар төлөвлөн хэлтсийн даргаар батлуулж ажиллана.
- 1.7. Гадаад харилцааны хэлтэс нь Засаг даргын Тамгын газрын албан бичгийн хэвлэмэл хуудас, хэлтсийн тэмдэг хэрэглэнэ.

Хоёр. Гадаад харилцааны хэлтсийн үүрэг :

- 2.1. Монгол улсын Үндсэн хууль, Монгол улсын гадаад бодлогын үндсэн зарчмууд, дипломат харилцаа, олон улсын харилцааны нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, НЗДТГ-ын дүрмийг үйл ажиллагаандаа үндэс болгон баримтлах.
- 2.2. Нийслэлийн гадаад харилцааны хөгжлийн хэтийн төлөв болон ойрын зорилт, төлөвлөгөөний төсөл зэргийг нийслэлийн эдийн засаг, нийгмийн нэгдсэн төлөвлөгөөнд тусгуулах, батлагдсан төлөвлөгөө, даалгавар, зорилтыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах.
- 2.3. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан нийслэлийн гадаад харилцаа, хамтын ажиллагааны хөгжлийн асуудлуудад бүх талын дүн шинжилгээ хийж, шаардлагатай мэдээлэл бэлтгэж хамгийн гол асуудлуудад хүч анхаарлыг төвлөрүүлж ажиллах.
- 2.4. Нийслэлийн гадаад харилцааны үйл ажиллагаатай холбоотой асуудлаар Монгол улсад суугаа гадаадын болон гадаадад суугаа Монголын ЭСЯ-дууд, Улаанбаатар хотод байгаа олон улсын байгууллагын төлөөлөгчийн газар, төсөл, үйл ажиллагаагаа явуулж байгаа гадаадын болон өөрийн үйлдвэрлэгчид, бизнес эрхлэгчид, мэргэжилтэн, хувь хүн болон хотын иргэдийн зүгээс гарах санал, бодол, хүсэлтийг байнга сонсох, хүлээн авч хянан үзэх, хууль тогтоомжинд нийцүүлэн нийслэлийн гадаад үйл ажиллагаанд ашиглах, нэвтрүүлэх, холбогдох газар, байгууллагуудаар дамжуулан шийдвэрлүүлэх, хариу өгөх.
- 2.5. Нийслэлийн удирдлага, НЗДТГ, дэргэдэх газар, хэлтэс, албан хаагчдыг нийслэлийн гадаад харилцаатай холбоотой мэдээллээр хангах, тэдэнд зөвлөгөө өгөх.
- 2.6. Улаанбаатар хотод гадаадын хөрөнгө оруулалтыг татах үүднээс Улаанбаатар хотын тухай болон Улаанбаатар хотод хэрэгжүүлэх төсөл, бизнесийн саналын талаар холбогдох байгууллага, хэлтэстэй хамтран тодорхой сувгаар сурталчилгаа хийх.
- 2.7. Нийслэлийн гадаад үйл ажиллагааг үр дүнтэй эрхлэн явуулах үүднээс НИТХ-ын ажлын алба, НЗДТГ-ын хэлтэс, дэргэдэх газар, хэлтэс, Нийслэлийн Ёслолын алба, "Улаанбаатар сан", нягт хамтран ажиллах, ажил үүргээ уялдуулах.

Гурав. Гадаад харилцааны хэлтсийн эрх :

- 3.1. Хэлтсийн эрхэлсэн ажлын чиглэлээр нийслэлийн гадаад харилцаатай холбоотой асуудал, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулж Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Тамгын газрын хэлтэс, холбогдох байгууллагад оруулах.

- 3.2. Нийслэлийн гадаад үйл ажиллагааны төлөвлөгөө , үндсэн чиглэл , гадаад бодлогын тодорхой асуудлуудыг боловсруулахад шаардагдах судалгаа , мэдээлэл , тайлан зэрэг материалыг дүүргийн Засаг даргын Тамгын газар , НЗДТГ-ын хэлтэс , дэргэдэх газар , хэлтэс , хэрэгжүүлэгч агентлаг , нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аль ч албан байгууллага , аж ахуйн нэгжээс гаргуулан авах , энэ чиглэлээр санал дүгнэлт боловсруулах , судалгаа хийх зэрэгт холбогдох ажил мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулах .
- 3.3. НИТХ , Нийслэлийн Засаг дарга , бусад удирдлага , НЗДТГ-тай зөвшилцсөний үндсэн дээр тэдний нэрийн өмнөөс нийслэлийн гадаад үйл ажиллагаатай холбоотой асуудлаар Монгол Улсын Засгийн газар , ГХЯ , төрийн яамд , хэрэгжүүлэгч газар , агентлагууд , Монгол Улсаас гадаад улсад суугаа болон гадаад улсаас Монголд суугаа ЭСЯ-дууд , харилцаа бүхий гадаадын хот , олон улсын байгууллага , үйлдвэрлэл , бизнес эрхлэгчид , хөрөнгө оруулагчид , хувь хүмүүстэй шууд харилцах , санал солилцох , хариу өгөх .
- 3.4. Хэлтсийн эрхэлж буй асуудлаар семинар , уулзалт , зөвлөлгөөн зохион байгуулах .
- 3.5. Нийслэлийн гадаад үйл ажиллагааны асуудлууд , энэ ажлын ололт , амжилт , дутагдал , доголдол , шийдвэрлэх арга замын талаар хэвлэл мэдээллийн бүх төрлийг ашиглаж сурталчилгаа явуулах .
- 3.6. Төрийн хууль , засгийн шийдвэр , Нийслэлийн Засаг даргын захирамжийн биелэлт , үр дүнг нутаг дэвсгэрийн харьяалалттай нийт байгууллага дээр хэрэгжүүлэх , шалгах ажлыг зохион байгуулах , дутагдлыг арилгах , шаардлага тавих , холбогдох арга хэмжээ авахуулах , шийдвэр гаргуулах .